

**“АЛСЫН ХАРАА -2050” МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН  
2024 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТ**

2024 оны 06 дугаар сарын 04

Улаанбаатар хот

№	Үндэслэж байгаа бодлогын баримт бичиг	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин		Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу гүйцэтгэлийн хувь /хүрээгүй бол шалтгаан, нөхцөл тайлбар/
				Он	Түвшин		
1	2	3	4	5	6	7	8
Зорилт 2.7.Монгол хүний удмын санг хамгаалж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх чадавхыг бэхжүүлж, монгол хүний хөгжлийг дэмжинэ.							
2.7.3.	Гадаадын иргэн, харьяалалгүй хүн, цагаачдын тооны зохист түвшнийг хадгалж, бүртгэл, мэдээлэл, хяналтын тогтолцоог боловсронгуй болгоно.	0.0	Гадаадын иргэн, харьяалалгүй хүний биеийн давхцахгүй өгөгдөл бүхий бүртгэлийн системийн хөгжүүлэлт	2023	Шинэчлэн хөгжүүлэх программ хангамжийн тоо-1	Үйл ажиллагаа хэвийн явагддаг болсон байна.	<p>2024 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 1881 гадаадын иргэн, үүнээс хамгийн их буюу Бүгд Найрамдах Хятад Ард Улсын 1253 иргэн Монгол Улсад цагаачлан оршин суухаар бүртгэлтэй байгаа нь Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.5 дахь хэсэгт заасан хэмжээнээс хэтрээгүй байна.</p> <p>Цахим хөгжил, харилцаа холбооны яам, И-Монгол академитай хамтран танилт нэвтрэлтийн ДАН системд гадаадын иргэний бүртгэл (F-Register) ашиглан нэвтрэх үйлчилгээг “Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан” (isf.mn) системтэй 2023 оны 11 дүгээр сарын 02-ны өдрөөс холбон үйлчилгээ үзүүлж байна.</p> <p>“Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан” isf.mn системд нийт 362 удаагийн засвар, шинэчлэлийг тухай бүр хийж, нэмэлт хөгжүүлэлтээр сайжруулан хэвийн ажиллагааг хангаж, тайлант хугацаанд визийн зөвшөөрөл, виз олголт, оршин суух зөвшөөрөл, гадаадын иргэний 48 цагийн бүртгэлтэй холбоотой 19861 хүсэлтийг хүлээн авч, тус тус хянан шийдвэрлэлээ.</p> <p>2024 оны хагас жилийн байдлаар тус системийн хөгжүүлэлтэд байгууллагаас төсөв зарцуулаагүй болно.</p>
Үнэлгээ 90 хувь							

--оо0оо--